



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дэх заалт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 4.2-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга /Ц.Одонбаяр/-д үүрэг болгосугай.
3. Төрийн албан хаагчдыг сургах сургалтын зардлыг жил бүрийн төсөвт суулгаж, ажиллахыг Ахлах нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/-д даалгасугай.



ДАРГА

Ц.ШАРАВЖАМЦ

000000600

07

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-  
Биеийн тамир, спортын газрын 2019 оны  
сарын 05 өдрийн А/ дугаар тушаалын хавсралт

232

**Биеийн тамир, спортын газрын  
албан хаагчдын сургалтын хөтөлбөр**

**Хөтөлбөрийн зорилго**

Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын мэдлэг боловсрол, ур чадвар, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэн мэргэшүүлэх, давтан сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн чадварлаг, салбарын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

**Нэг: Нийтлэг үндэслэл**

Төрийн албанд оюунлаг, бүтээлч чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй тулгараад байгаа өнөө үед албан хаагчдын боловсролыг дээшлүүлэх асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. Тус байгууллагын албан хаагчид нь төрийн албан хаагч болохын хувьд үйл ажиллагаандаа хуулийг дээдлэн мөрдөж, ёс зүйтэй, харилцааны өндөр соёлтой, ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна. Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дугаар заалт нь албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах үндэслэл болно.

**Хоёр: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

- 2.1. Сургалтын хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулах бүрэлдэхүүн:  
- Биеийн тамир, спортын газрын даргын зөвлөл.
- 2.2. Биеийн тамир, спортын газрын даргын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн жилийн сургалтын асуудлыг тусгаж батлуулж хэрэгжүүлнэ.
- 2.3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, жил бүр хэрэгжилтийн явцыг гаргаж тайлагнах үүргийг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс хэрэгжүүлнэ.
- 2.4. Биеийн тамир, спортын газрын төрийн жинхэнэ албан хаагчдыг Мэргэшүүлэх багц сургалтад хамруулах, Удирдлагын академиас зохион байгуулж буй богино хугацааны болон зайн сургалтад бодлогоор хамруулах үүргийг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс хүлээнэ.
- 2.5. Биеийн тамир, спортын газрын удирдлага нь байгууллагад зайлшгүй шаардлагатай мэргэшлийн сургалтад ажилтан, албан хаагчдыг хамруулах талаар байнга дэмжиж ажиллана.



2.6. Биеийн тамир, спортын газрын нэгжийн дарга нар нь ажилтан, албан хаагчдаа мэргэжлийн сургалтад хамруулах тал дээр онцгой анхаарч ажиллана.

2.7. Байгууллагын удирдлага нь албан хаагчийг сургах, давтан сургах, хөгжүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх нөхцөлөөр ханган дэмжлэг үзүүлэх, албан хаагчид нь өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бусад албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулахад хамтран ажиллах үүргийг тус тус хүлээнэ.

2.8. Сургалт явуулах анги танхимыг бий болгож, сургалтын материаллаг бааз, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

2.9. Жил бүрийн төсөвт төрийн албан хаагчдыг сургах сургалтын зардлыг суулгаж, хэрэгжүүлнэ.

### **Гурав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим, чиглэл**

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтлана.

- Захирах, захирагдах ёс;
- Ил тод байх;
- Төрийн алба мэргэшсэн тогтвортой байх;
- Төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах;
- Хууль дээдлэх зэрэг болно.

3.2. Сургалтын хөтөлбөр нь дараах чиглэлтэй байна.

#### **-Гадаад сургалт:**

Гадаад орнуудын спортын ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, санамж бичигт Биеийн тамир, спортын газрын /цаашид "Газар" гэнэ/ ажилтнуудыг туршлага судлуулах, богино хугацааны сургалтад хамруулах асуудлыг тусгаж хэрэгжүүлэх:

Гадаадын богино хугацааны мэргэшлийн сургалтыг 2 жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, байгууллагын албан хаагчдын 40-өөс доошгүй хувийг хамруулах:

Гадаад сургалтыг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс, Гадаад харилцаа, статистик, мэдээлэл, технологийн хэлтэс хамтран зохион байгуулна.

#### **-Дотоод сургалт:**

Төрийн жинхэнэ албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад хамруулах

Төрийн албан хаагчдыг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн сургалт болон бусад сургалтын хөтөлбөрийн талаархи мэдээлэлээр шуурхай хангаж, өргөн хамруулах.

Манай улсад зохион байгуулагдаж буй олон улсын болон төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын хурал, зөвлөлгөөн, сургалтад байгууллагын төрийн албан хаагчдыг оролцуулах



### **-Ажлын байранд зохион байгуулах сургалт.**

Байгууллага дээр зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, төсвийг жил бүрийн эхэнд батлаж, хэрэгжүүлнэ.

Байгууллага дээр зохион байгуулах сургалтыг 14 хоногт 1 удаа зохион байгуулахаар төлөвлөж, нэгжүүдэд хариуцуулан төлөвлөгөө гарган зохион байгуулж хэвшүүлэх. /Нэгжүүд ээлж дараалан, хуваарийн дагуу сургалт явуулна/

Байгууллагын сургалтыг зохион байгуулахдаа гадаад, дотоодын эрдэмтэн, сургагч, багш нарыг урьж хичээл заалгана. Сургалтыг орчин үеийн дэвшилтэт хэлбэрүүдээр мөн асуудал дэвшүүлэх, харилцан ярилцах хэлбэрээр зохион байгуулж, суралцагсдыг гарын авлага материалаар хангах;

Байгууллага дээр зохион байгуулах сургалтын сэдэв нь албан хаагчдад зайлшгүй шаардлагатай, мэдлэг, мэдээллээр хангахад чиглэгдэнэ. Жишээ нь:

- Удирдах албан тушаалтан, төрийн жинхэнэ албан хаагчийн манлайлал:
- Төрийн албан хаагчийн ёс зүй:
- АТГ-ын сургалт:
- Хуулийн сургалт
- Төрийн албаны зөвлөлийн сургалт:
- Байгууллагын соёл:
- Харилцааны соёл:
- Албан бичиг хэрэг хөтлөлт:
- Биеийн тамир, спортын салбарын хөгжил гэх мэт.

### **Дөрөв. Сургалтын хэлбэр.**

- Шууд сургалт:
- Зайны сургалт:
- Интернэт сургалт:
- Байнгын, тасралтгүй сургалт:
- Бие дааж суралцах сургалт
- Захиалгат сургалт:
- Бусад.

### **Тав: Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Улсын төсөв;
- Хамтран ажилладаг Гадаадын БТС-ын байгууллагын тусламж, дэмжлэг, хандив, Төсөл:
- Бусад эх үүсвэр.

## **Зургаа: Хөтөлбөрийн үр дүн, хэрэгжүүлэх хугацаа**

6.1 Хугацаа: Сургалтын хөтөлбөрийг 2019-2024 онд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жилд нэг удаа үнэлэлт, дүгнэлт хийж, шаардлагатай бол хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

### 6.2 Үр дүн:

6.2.1 Сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, техник, технологийн шинэчлэл хийгдэж, чанартай сургалтын орчин бүрдүүлэх;

6.2.2 Сургалт явуулсны үр дүнд албан хаагчдын харилцааны соёл, төрийн албан хаагчийн ёс зүй, хууль эрх зүй, мэдлэг, боловсрол дээшилж, биеийн тамир, спортын салбарын хөгжлийн зүй тогтол, менежмент, тулгамдаж буй асуудлуудын талаар харилцан ярилцаж, тодорхой нэгдсэн дүгнэлтэд хүрсэн байх;

6.2.3 Гадаад орны ижил төстэй байгууллагын үйл ажиллагаа, хамтын ажиллагааны боломж, олон улсын арга хэмжээ зохион байгуулах туршлага судалж, мэдлэг, боловсрол, мэргэшил дээшлүүлсэн байх;

6.2.4 Төрийн захиргааны албан хаагчид тавигдах шаардлагыг хангасан байх;

6.2.5 Ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан мэргэжилтэн бэлтгэгдсэн байх.

### **Долоо: Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

Хөтөлбөрийн хэрэгжилтэд дараах үзүүлэлтийг үндэслэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

7.1 Албан хаагчдын мэдлэг, боловсрол, ур чадвар дээшилсэн байдал;

7.2 Төрийн албан хаагчдын үнэлэмж нэмэгдсэн байдал;

7.3 Сургалтад хамрагдагсдын ажлын үзүүлэлт;

7.4 Гадаадад томилолтоор ажилласан байдлыг нэгж тус бүрээр гаргаж дүгнэлт гаргасан байх;

7.5 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Биеийн тамир, спортын газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэнэ.